

“СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Орхон аймаг

2025.12.16

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төсөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв, эх үүсвэр (сая төг)		
Зорилго: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хянах, бэхжүүлэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.						
Зорилт 1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль, эрх зүйн орчин, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.						
1.1	Сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, хэм хэмжээ, хууль тогтоомжийг мөрдөх арга хэмжээг зохион байгуулах	Төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулж, хэрэгжилт 82% хүрсэн байна.	4,0 сая ОНТ	3,0 сая ОНТ	Сэтгэцийн эрүүл мэндийн 2025 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулан, төлөвлөгөөний дагуу төрийн болон төрийн бус 55 байгууллагатай хамтран 38 төрлийн сургалт, үйл ажиллагаанд 18215 төрийн байгууллагын албан хаагчид болон үйлдвэрийн ажилчид, эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ерөнхий боловсролын сурагчдыг хамруулж, 10 төрлийн гарын авлага, зөвлөмжийг давхардсан тоогоор 2408 иргэнд түгээж ажилласан байна. - Тайлант хугацаанд сэтгэцийн өвчлөл 1371 бүртгэгдэж 10 000 хүн амд 128.9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.3 промиллоор буурсан байна. Сэтгэц нөлөөт эмийн бодисын шалтгаант сэтгэцийн аягийн эмгэг 498 бүртгэгдэж 10 000 хүн амд 46.8 промил өнгөрсөн оны мөн үеэс 2.0 промилоор буурч, архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг шалтгаант өвчлөлөөр 416 хүн хэвтэн эмчлүүлсэн ба 10 000 хүн амд 39.1 промил өмнөх оны мөн үеэс 0.2 промилоор өссөн байна. -	100
1.2	Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээний төв байгуулах бэлтгэл ажлыг хангах, мэргэжилтнүүдийг бэлтгэх	Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж эмнэл зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, хөдөлмөр заслын тусламж үйлчилгээг тогтмол хүргэж	-	-	- Аддиктологийн төв, Сэтгэц нийгмийн сэргээн засах төв, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хороотой хамтран “Архины хамааралтай хүнд үзүүлэх сэтгэц–нийгмийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох төрийн байгууллагуудын 44 албан хаагчдыг хамруулсан. - Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн хөгжлийн хорооны 2025 оны 05 дугаар сарын	70

		ажилласан байна.			02-ны өдрийн 02/12 дугаартай албан бичиг, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/292 дугаар захирамж, удирдамжийн дагуу архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв”, “Аддиктологийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, улмаар орон нутагт бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх төв байгуулах, донтох эмгэгийн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудын 10 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судалсан. Мөн орон нутагт Сэтгэц-нийгмийн сэргээн засах төвийг нутагшуулах зорилгоор 2026 оны орон нутгийн төсөвт 320,0 сая төгрөгийг тусгуулаад байна.	
1.3	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг сэтгэцийн эмнэлэгүүдэд бий болгох	Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж эмнэл зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, хөдөлмөр заслын тусламж үйлчилгээг тогтмол хүргэж ажилласан байна.	-	-	- Аймгийн хэмжээнд сэтгэцийн тусамж үйлчилгээг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник, хувийн хэвшлийн 2 клиник үзүүлж байна. Мэргэжлийн сэтгэцийн 6 эмч ажиллаж байна. - Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сэтгэл зүйчид сэтгэл зүйн болон мэргэжил сонголт, эрүүл мэнд хүчирхийлэлтэй холбоотой ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө үйлчилгээг үзүүлж байна. - Мэргэжлийн сэтгэл зүйчдээс бүрдсэн “Ариунсаруулбат”, “Бодь шид”, “Ариун хэлхээ”, “Мэдрэмж”, “Сэтгэл амар”, “Сэтгэл зүйн цогц боловсролын төв”, “Гэр бүлийн гишүүдийн чадавхжуулалтын төв”, “Сэтгэлийн эгшиглэн”, “Анир мэдрэмж”, “Хүмүүнлэгийн сэтгэл зүйн төв” төрийн бус 9 байгууллага, Архидалт, мансуурлын эсрэг ассоциаци Орхон Аймаг Дахь Салбар ажиллаж байна. - Эрдэнэт клиникийн сэтгэцийн кабинетаар 1960 хүн үйлчилгээ авч, идэвхтэй хяналтад 42, үүнээс эдгэрсэн 35 үйлчлүүлэгч байна. 52 удаагийн сургалтад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 3487 ажилтан, аутотренингд 620 хүн хамрагдсан байна. - БОЭТ-ийн Сэтгэц-наркологи тасагт 579 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс: F10 бүлэг буюу архины хордлого оношоор 177, Сэтгэцийн эмгэгийн бусад оношоор 402	100

					хэвтэн эмчлүүлэгчид хэвтэн эмчлүүлсэн. Тасаг нь Хөдөлмөр засал, ном, хөгжим, арт терапи зэрэг заслын эмчилгээ хийж ажилладаг. -Сэтгэц наркологийн хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн “Оюу” эмнэлэгт нийт 441 хүн хэвтэн эмчлүүлсэнээс 257 хүн нь архины хордлого тайлах эмчилгээ хийлгэсэн. Хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилладаг.	
1.4	Сум, өрхийн эмнэлгүүдэд сэтгэл зүйч ажиллуулж, иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх	Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, хөдөлмөр заслын тусламж үйлчилгээг тогтмол хүргэж ажилласан байна.	-	-	-Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 3 эрүүл мэндийн төв Сэтгэл зүйч ажиллуулж иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. - Баян-Өндөр сумын 26 багт Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хүүхэд, гэр бүлийн 22 нийгмийн ажилтан, 26 хамтарсан баг ажиллаж байна. - Орхон аймгийн иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж буй сэтгэл зүйчдийг чадавхжуулах, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд тусламж үйлчилгээг чанартай хүргэх зорилгоор 41 сэтгэл зүйч нэгдэж анхны хурлыг зохион байгуулж “Орхон аймгийн сэтгэл зүйчдийн холбоо”-г байгуулсан.	100
1.5	Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	Эрүүл мэндийн үйлчилгээ авч буй иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, хөдөлмөр заслын тусламж үйлчилгээг тогтмол хүргэж ажилласан байна.	-	-	-Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуульд “Хүүхдийн төлөө хамтдаа” өдөрлөг зохион байгуулж 125 эцэг эх асран хамгаалагчдад сэтгэл зүйн тест оношилгоо хийж, зөвлөгөө өгч ажилласан. - “Эрүүл мэндийн өдөрлөг” зохион байгуулж малчдын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдралын талаар эрүүл зан үйлийг сурталчлах, стресс, сэтгэл гутралын ялгаатай байдал, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Тус өдөрлөгт нийт 60 гаруй иргэд хамрагдсан. - Архидан согтуурах, мансуурах, донтох эмгэгээс сэргийлж ӨЭМТ-үүд нь өөрийн пэйж хуудсаараа 74 удаагийн цахим хуудсаар дамжуулан цахим залилан, архи, тамхи мансуурах бодис, сэтгэлзүйн чиглэлээр мэдээлэл оруулж 82800 иргэнд хүргэсэн байна. Мөн мансууруулах бодис буюу тамхинаас гарах цаасан зөвлөгөөг 70 иргэнд хүргэсэн. - Тамхины тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Эрдэнэт сувиллын цогцолборын сэтгэл засалч эмчийн хяналтанд 126 ажилтан байснаас 38 хүн тамхинаас	100

					гарсан. 29 хүн эмийн эмчилгээ хийлгэж байна. Өрхийн эмнэлгийн хяналтанд 48 иргэнд тамхинаас гаргах чихний зүү эмчилгээг хийж 13 иргэн тамхинаас гарсан 28 иргэн тамхины бага хамааралтай болсон.	
1.6	Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллуулах	Боловсролын байгууллагын сэтгэл зүйч, нийгмийн ажилтан сургууль, хамт олны түвшинд зөвлөгөө өгч ажилласан байна.	-	-	- Ерөнхий боловсролын 24 сургуулийн 19 эмч, 29 нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн 22 сэтгэл зүйч сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. - Сургуулийн өмнөх боловсролын 38 цэцэрлэгт 2 сэтгэл зүйч, 20 эмч ажиллаж тусламж үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд хамтарсан 26 багт нийт 251 кейс бүртгэгдэж үүнээс 203 тохиолдол дээр кейс менежментийн зарчим, алхмын дагуу хамтарсан багийн гишүүд уялдаа холбоотой ажиллаж шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд эцэг, эх асран хамгаалагчдын үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 112 хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үйлчилгээ үзлэг, оношилгоонд хамруулсан байна.	100
1.7	Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, хамтын гэрээнд тусган мөрдөж ажиллах, хамт олныхоо сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	-	-	-Тайлант хугацаанд 15 байгууллагатай хамтран “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх” сургалтуудыг зохион байгуулж 441 албан хаагч хамрагдсан. - “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих дунд хугацааны хөтөлбөр буюу “Сэтгэл зүйн эрүүл мэндийн хөтөлбөр 2024-2028”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсэг 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс томилогдон, төлөвлөгөө гарган ажиллаж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын шинээр ажилд орж буй ажилчдад ХАБ, хоол зүй, сэтгэцийн эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулдаг ба 156 шинэ ажилтан хамрагдсан. - “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр II”-ын хүрээнд Халдварт бус өвчин, хорт зуршлын чиглэлээр сургалтыг зохион байгуулж 150 гаруй албан хаагчийг хамруулсан. -Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраас санаачлан албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 70 гаруй байгууллагын мэргэжилтнүүдийг хамруулсан 2027 он хүртэл хэрэгжих “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төслийг эхлүүлэн амжилттай хэрэгжүүлээп байна.	100
1.8	“Дэлхийн тамхигүй орчны	Тамхины хэрэглээг	-	-	Тайлант хугацаанд 2 төрлийн үйл ажиллагаа зохион	100

.	өдөр"-ийг тохиолдуулан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	бууруулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.			байгуулж ажилласан. Үүнд: - Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 7 удаагийн өдөрлөг зохион байгуулж 1510 иргэнд хорт зуршил, электрон тамхи, дам тамхидалт, хорт зуршил нь эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг болон Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. - Тамхины хяналтын хуулийг хэрэгжүүлэх, Дэлхийн тамхигүй өдрийг тохиолдуулан 3 удаагийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж 10 пэйж хуудас, 2 сум, 29 багийн пэйж хуудсаар мэдээлэл оруулж давхардсан тоогоор 494 мэдээлэл оруулж, хандалтын тоо 115254, 279 лайк, 98 шэйртэй иргэдэд түгээж ажиллалаа. - 2 сумын 28 багийн нутаг дэвсгэрт Тамхи болон тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 57 дэлгүүрт хяналт хийж, зөвлөмж, уриалга хүргүүлсэн ба Жаргалант сумын ЕБС-ийн дунд, ахлах ангийн хүүхдүүдийн дунд электрон тамхины хэрэглээнд 7 удаа хяналт хийж, илрүүлэх, арилгах ажлыг зохион байгуулсан. - СЭМҮТ-өөс зохион байгуулсан “Тамхинд донтох эмгэгийг эмчлэх сэтгэц, зан үйлийн болон эмийн эмчилгээ” онлайн сургалтад 10 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан. - 2 ӨЭМТ тамхины хор нөлөөний чиглэлээр мэдээллийг иргэдэд дэлгэцээр тогтмол хүргэж байна. Ерөнхий боловсролын 5 сургуулийн дунд, ахлах ангийн сурагчид болон төрийн болон Эрүүл мэндийн байгууллагууд “Тамхийг бус эрүүл мэндээ сонгоё”, “Хордохоос татгалзъя” аянд нэгдэж иргэдэд нөлөөллийн сурталчилгаа хийсэн. - Аймгийн хууль, эрх зүйн хэлтсийн “Хуулийн цаг” нэвтрүүлэгт Электрон тамхины хор хөнөөлийн чиглэлээр 2 эмч оролцож тамхи эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаар мэдээлэл, зөвлөмж хүргэсэн. - Тамхины хор нөлөөний талаар 40 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн 4175 оюутан, сурагчид, 880 иргэд хамрагдаж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын цехүүдийн 65000 ажилчдад “Өглөөний ХАБ”-аар “Электрон тамхины хор хөнөөл”-ийн мэдээллийг түгээж, 10 төрлийн 2408 иргэнд тараах материал тараасан. - УИХ-ын Тамгын газраас Тамхины хяналтын тухай	
---	---	---	--	--	---	--

					хуулийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх цахим судалгаанд ЭМГ-ын 33 албан хаагчийг хамруулсан. - Электрон тамхинаас татгалзах эрүүл амьдарлын хэв маягийг төлөвшүүлэх, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сумын ЭМТ-ийн ажилтан албан хаагчдын дунд спортын тэмцээн зохион байгуулж, 18 албан хаагч хамрагдсан.	
Зорилт 2. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах						
2.1.	Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн түвшинг тодорхойлох тандалт судалгаа хийх	Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтыг үнэлэх арга аргачлалыг боловсруулж, судалгааг авсан байна.	-	-	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стрессийг илрүүлэх асуумж (DASS-21) Depression anxiety stress scale (DASS-21) асуумжийн DASS-D, DASS-A, DASS-S гэсэн 3 хэмжүүр тус бүр нь 7 асуултаас бүрддэг ба тус асуумжаар Цагаан тоосны бүсэд оршин суудаг иргэдээс түүврийн аргаар судалгаа авч авч ажиллалаа. Тус судалгаанд 17-65 насны 486 хүн хамрагдсан. Үнэлгээгээр сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стресс хэвийн үнэлэгдсэн 290 хүн байсан. <u>DASS-D</u> буюу Сэтгэл гутрал хөнгөн хэлбэрийн n-22, дунд зэрэг n-18, хүндэвтэр n-5, хүнд n-6 хүн, <u>DASS-A</u> буюу Сэтгэл түгшилт хөнгөн хэлбэрийн n-34, дунд зэрэг n-21, хүндэвтэр n-22, хүнд n-24 хүн, <u>DASS-S</u> буюу стресс хөнгөн хэлбэрийн n-8, дунд зэрэг n-17, хүндэвтэр n-11, хүнд n-8 хүн байсан тул 196 хүнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 8 хүнийг сэтгэцийн эмчид холбон зуучилж, эмийн эмчилгээ зөвлөж хяналтад авсан байна.	70
2.2.	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сэтгэлзүйч, багш, нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулж, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тогтмол явуулах	Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлж эхэлсэн байна.	-	-	-СЭМҮТ-тэй хамтран Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Онцгой байдлын газар, Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг хамруулан “Тоглоомын хамаарлын сэтгэц-нийгмийн асуудал” сургалтыг зохион байгуулж 120 мэргэжилтэнг чадавхжуулсан. - “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан. -Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “Гамшгийн үеийн сэтгэл зүй”, “Уй гашууг даван туулах нь”, “Стресс менежмент” сургалтад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан	100

					эмч нар нийт 78 мэргэжилтэнг хамруулан чадавхжуулсан байна.	
2.3.	Хүүхдийн байгууллагын орчинд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	-	-	- Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд Эрүүл мэндийн боловсрол олгох 7 удаагийн өдөрлөгт сургуулийн өмнөх болосролын байгууллага болон Ерөнхий боловсролын сургуулийн 566 хүүхдэд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. - “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аян зохион байгуулагдаж нээлтийн арга хэмжээний сургалт хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 120 сурагчид хамрагдаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон. Тус аяны хүрээнд 8 сургуулийн 968 сурагчдад сэтгэл зүйн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч, 415 тараах материал тарааж ажилласан. - Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ШШГГ-ын хяналтад байдаг 21 хүүхдэд “Эрүүл бус хүнсний хэрэглээ, Өсвөр насныханд зонхилон тохиолдох хоол боловсруулах замын эмгэг, хорт зуршил” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.	70
2.4.	Хүүхэд, өсвөр үеийг цахим халдлага, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах зэрэг хорт зан үйлээс ангид байх нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай явуулах	Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж эхэлсэн байна.	-	-	- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас Улсын хэмжээнд зохион байгуулж буй “Анзаар-2” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Мансууруулах бодис, түүнээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 8 удаа зохион байгуулж 12 байгууллагын 2400 албан хаагчид болон сургуулийн ахлах ангийн хүүхдүүд, эцэг эхчүүдийг хамруулсан. - Үеийнхээ найз нөхдийг бүү дээрэлхээрэй, бусдын эд зүйлийг хулгайлах хориотой, дээрэлхэлт гэж юу вэ сэдвийн хүрээнд хүүхэд бүрийн сонирхол, онцлог хэрэгцээнд нь тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим хуудсаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллаж байна. - Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран "Цахимд өнгөрүүлж буй цагаа өөрт хэрэгцээт мэдээллээ олж авахад ашиглая, мэдсэн сурснаа бусадтай хуваалцдаг байя" уриатай “Өсвөр насны хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудал болж буй электрон тамхи эрүүл мэндэд учруулах хор уршиг, нөлөөлөл”-ийн талаар ярилцсан “ХЭРЭГТЭЙ ХОВ”	100

					подкаст хийж цахимаар түгээсэн. - “Хордохоос татгалзъя” нөлөөллийн аянд төрийн байгууллагууд, ААНБ-ууд болон ЕБС-ийн сурагчдыг хамрагдаж ажилласан. - Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнхан болон политехник коллежийн оюутнуудад ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах зэрэг хорт зан үлээс сэргийлэх, хор уршгийн сургалтуудыг зохион байгуулж 1952 оюутан, өсвөр үеийн хүүхдүүд хамрагдсан байна .	
2.5.	Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн цахим орчинд нөлөөллийн ажлууд зохион байгуулах	Нөлөөллийн ажлыг зохион байгуулж иргэдэд түгээж, цахим хуудас дахь хандалтын тоо 20%-иар өссөн байна.	-	-	Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд дараах фэйсбүүк хуудас ажиллаж байна. Үүнд: - Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлийн 74 зурган постер, 26 видео шторк, 9 рийл, 189 мэдээлэл бэлтгэн оруулж 182243 хандалт авсан байна. - “Жаргалант сумын эрүүл мэндийн төв” пэйж хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ мэдээлэл хүргэсэн байдал хагас жилийн байдлаар 83 төрлийн 101 мэдээллийг постер болон бичлэг хэлбэрээр бэлтгэн түгээж хандалтын тоо 102,611 байна. Мөн өрхийн эрүүл мэндийн 8 төвийн пэйж хуудсаар мэдээллүүдийг тогтмол оруулж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж байна. - “Катарсис сэтгэл заслын эмнэлэг” фэйсбүүк хуудас /3,6M/ - “erdenet Setgel zuich (Өөрөөс эхлэх амьдрал)” фэйсбүүк хуудсаар /88/ онлайн зөвлөгөөг өгч ажиллаж байна. - “Амар Амур” фэйсбүүк хуудас /7,8M/ - “Сэтгэл зүйн цогц боловсролын төв”нь сэтгэл зүйн судалгаа оношилгоо, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд “Сэтгэл зүйн цогц боловсролын төв” пэйж хуудсыг (4,1M) сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр тогтмол ажиллуулж байна. - “Гэр бүлийн гишүүдийн сэтгэл хөдлөлийн дасгалжуулалтын төв НҮТББ” фэйсбүүк хуудас /3,5M/ - Хүмүүнлэгийн сэтгэл судлалын төв” ТББ фэйсбүүк хуудас /0,3M/ - Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт	100

					оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан, хуулийн төслийн зүйл, заалтуудад 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор эрүүл мэндийн байгууллагуудаас санал авч нэгтгэн хүргүүлсэн байна.	
2.6.	Аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагчдад архи, согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи, дам тамхидалтын хор нөлөөг таниулах сурталчлах, соён гэгээрүүлэх, ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх	Аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагчдад архи, согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи, дам тамхидалтын хор нөлөөг таниулах сурталчлах, соён гэгээрүүлэх, ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, төрийн болон ТББ, олон нийтийн хөдөлгөөнийг дэмжих ажлыг зохион байгуулсан байна.	-	-	- Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 8 удаагийн өдөрлөгт /Сэтгэцийн эрүүл мэндийн өртөө, хорт зуршлын өртөө, эрүүл зөв хооллолтын хоол зүйн өртөө, эрүүл хэв маягийг хэвшүүлэх өртөө ажилласан/ тухайн нутаг дэвсгэрт байрладаг цэргийн байгууллага, гаалийн газар, Төмөр замын өртөө, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд 944 хүн хамрагдсан. - ШШГЕГ-н Хойд бүсийн чуулга уулзалтанд "Эрүүл амьдралын хэв маяг ажлын бүтээмжинд нөлөөлөх нь" сэдвээр сургалт зохион байгуулж 51 албан хаагч хамрагдсан. - Архи бидний сонголт биш аяны хүрээнд “Архи тамхи шинэ үеийн сонголт биш”, “Хорт зуршил гэж юу? Хүүхдээ хэрхэн хамгаалах вэ? нөлөөллийн ажил, сургалт зохион байгуулж эрүүл мэнд, боловсролын байгууллагын 555 албан хаагчдыг хамруулсан ба архи, тамхины хор хөнөөлийн тухай 4 төрлийн тараах материалыг 218 иргэд түгээсэн.	70
2.7.	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх 3 арга хэмжээг явуулсан байна.	-	-	Тайлант хугацаанд 28 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 5 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 7387 хүн хамрагдсан. Үүнд: - Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 8 удаагийн өдөрлөгт Сэтгэл зүйн зөвлөгөөний өртөө ажиллаж Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгож, зөвлөгөө өгч ажилласан. 566 хүүхэд, 944 хүн буюу 1510 хүн хамрагдсан. - 12 байгууллага хамтран АНУ, Эмори их сургуулийн “Танин мэдэхүйд суурилсан энэрэнгүй сэтгэлийг хөгжүүлэх бясалгал” 2 удаа, “Оксфорд Майндфүлнэсс – Санамсрын бясалгал” 6 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 3520 иргэн хамрагдсан. - Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөгөөр Эрүүл мэндийн өртөө Эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. Тус өдөрлөгөөр 497 хүн хамрагдсан. - Малчдын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл	100

					идэвхтэй амьдралын талаар эрүүл зан үйлийг сурталчлах, стресс, сэтгэл гутралаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Тус өдөрлөгт нийт 60 гаруй иргэд хамрагдаж, цахимаар 30 төрлийн мэдээлэл оруулж 9200 гаруй хүнд хүргэж ажилласан. - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг танилцуулах, иргэдийг сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамруулах зорилгоор “Гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэнд” өдөрлөг зохион байгуулж 2 удаагийн давтамжтай 5 төрлийн сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, төрийн болон төрийн бус 11 байгууллагын 11 өртөө ажиллаж иргэдэд сэтгэл зүйн мэдээлэл хүргэх, тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан. Өдөрлөгт 1800 иргэн хамрагдав.	
2.8.	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамарсан эмнэлгийн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн бүлгийн ярилцлага зохион байгуулах	Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.	-	-	- “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан. - “Стресс менежмент”, “Ажлаас халшрах хам шинжээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, “Миний мэргэжил миний бахархал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Тамхины хор нөлөө - хэрэглэхээс татгалзах нь”, “Тамхины тухай хууль”, “Стрессийг эерэгээр даван туулах нь, Зөөлөн ур чадвар, Байгууллагын соёлын өөрчлөлт ажилтны оролцоо, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, Сэтгэцийн эрүүл мэнд гэж юу вэ?” сэдвээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр орж байгаа эмч, мэргэжилтнүүд, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Баян-Өндөр мед эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд давхардсан тоогоор 491 хүн хамрагдсан.	100
2.9.	Жирэмсэн болон төрсний дараах эхчүүдэд сэтгэл зүйн алхамчилсан	Үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж	-	-	- 16-49 насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд өдөрлөг зохион байгуулж ажилласан. Тус өдөрлөгт нийт 85 эмэгтэйчүүд хамрагдсан.	70

	бүлгийн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулах	хэрэгжүүлсэн байна.			- “Охидын эрүүл мэнд” өдөрлөг зохион байгуулж Орхон Политехник коллежийн 60 оюутанд Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл хүргэж ажилласан. - Жаргалант сумын “Эмэгтэйчүүдийн зөвлөгөөн”-нд хамрагдаж буй 160 эмэгтэйд “Эрүүл амьдралын хэв маяг” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. - Эмэгтэйчүүд өдөрлөг зохион байгуулж 16-49 насны зорилтот бүлгийн 85 эмэгтэйчүүд хамрагдаж эрүүл мэндийн боловсрол олгож, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилго хийж ажилласан. Мөн анхан болон давтан төрөх жирэмсэн 244 ээжүүдээс хүчирхийлэлийн асуумж авахад 2 тохиолдол илэрсэн тул харьяаллын хамтарсан багтай хамтран асуудлыг холбон зуучилсан. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд эмэгтэйчүүдэд жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр тогтмол зөвлөгөө, мэдээлэл өгдөг ба сэтгэцийн эмгэгтэй 5 эмэгтэйд жирэмснээс сэргийлэх арга хэмжээ авч, 3 эмэгтэйг нас харгалзахгүй умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээнд хамруулсан.	
2.10.	Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг хүүхэд болон тэдний асран хамгаалагч нарт сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.	-	-	- БОЭТ-д Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдсэн, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал хангагдах “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж – ээлтэй орчин бүрдүүлэх” төсөл хэрэгжихээр төлөвлөгдөж байна. - АШУҮИС, АУС-ийн Сэргээн засах анагаах ухааны тэнхим “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран сургалт, үзлэгийг 2 өдрийн турш зохион байгуулсан. “Хүүхдийн хөгжил хөдөлгөөний онцлог”, “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн онцлог, хөгжүүлэх арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөдөлмөр засал, зөв байрлалын менежмент, хооллолт” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж 38 хүн хамрагдсан. - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулсан Аутизмын хүрээний эмгэг оношлох CARS сургалтад сэтгэцийн 2 эмч, ADOS-ын сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан. - Аутизмын хүрээний эмгэг оношлох нэгж байгуулах, орон нутагт нутагшуулах зорилгоор санал оруулан ажиллаж байна.	70
2.11.	“Амиа хорлох оролдлого	Эрүүл мэндийн	-	-	- 2 байгууллагатай хамтран сум, өрхийн эмнэлгийн эмч	70

	хийсэн хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай” ЭМС-ын А\149-р тоот тушаалыг танилцуулах, хэрэгжилтийг хянах	сайдын А/149-р тушаалыг танилцуулсан байна.			мэргэжилтнүүдэд “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай” ЭМС-ын А\149-р тоот тушаалыг танилцуулж, арга зүйгээр хангаж ажилласан. - БОЭТ-н Сэтгэцийн тасагт ШШГА-ны тогтоолын даргуу Нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болох Ds: F06.2–Органик дэмийрлийн эмгэг оноштой 1 эмлүүлэгчийг 1 сарын албадан эмчилгээнд, амиа хорлох оролдлого хийсэн Ds: Солиорлын шинж тэмдэг бүхий гүнзгий сэтгэл гутрах эмгэг оноштой 1 эмчлүүлэгч, солиорлын шинж тэмдэггүй гүнзгий сэтгэл гутрах эмэг оношоор 1 хүүхэд, дасан зохицохын эмгэг, сэтгэл гутралын хам шинж оношоор 1 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн.	
2.12.	Мөрийтэй тоглоомын хор уршгийг таниулах сургалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.	-	-	- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв , “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Үйлдвэрчний хороотой хамтран “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилчдад “Мөрийтэй тоглоомоор мөнгө олохгүй” сургалтыг 3 удаа зохион байгуулж 710 ажилтан хамрагдсан. - “Мөрийтэй тоглоомын хамаарал, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг зохион байгуулж Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын албан хаагчид, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчид, Онцгой байдлын газрын 120 албан хаагч хамрагдсан.	100
2.13.	Архидан согтуурахаас сэргийлэх сарын аяны хүрээнд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.	-	-	- Аймгийн хэмжээнд сэтгэцийн тусламж үйлчилгээг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник, хувийн хэвшлийн 2 клиник үзүүлж байна. Мэргэжлийн сэтгэцийн 6 эмч ажиллаж байна. - Мэргэжлийн сэтгэл зүйчдээс бүрдсэн 9 төрийн бус байгууллагууд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгч, Архидалт, мансуурлын эсрэг ассоциаци Орхон Аймаг Дахь Салбар тогмол ажиллаж байна. - БОЭТ-ийн Сэтгэц-наркологиын тасагт 579 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс: F10 бүлэг буюу архины хордлого оношоор 177, Сэтгэцийн эмгэгийн бусад оношоор 402 хэвтэн эмчлүүлэгчид хэвтэн эмчлүүлсэн. Тасаг нь Хөдөлмөр засал, ном, хөгжим, арт терапи зэрэг заслын эмчилгээ хийж ажилладаг. - Сэтгэц наркологиын “Оюу” эмнэлэгт нийт 441 хүн хэвтэн эмчлүүлсэнээс 257 хүн нь архины хордлого	90

					тайлах эмчилгээ хийлгэсэн. Хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилладаг. - Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаалаар батлагдсан тэмдэглэлт өдрүүдийн нэг болох "Архидан согтуурахаас сэргийлэх 10 хоног"-ийн аяны хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн 1100 ажилтанд хорт зуршлаас татгалзах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 1732ш гарын авлага тарааж ажилласан. - Эрдэнэт клиникийн сэтгэцийн кабинетаар Архины хамаарлын чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөнд 214 хүн хамрагдсан байна. - Архины хамаарлаас болж амиа хорлох оролдлого хийсэн 1 ахмад настанг Сэтгэц, наркологийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлсэн. - Баян-Өндөр сумын Дэнж баг, Орхон аймгийн Цагдаагийн газрын хэв журмын тасагтай хамтран Дэнж багийн архинд донтох эмгэгтэй 10 хүнд "Архи хүний биед нөлөөлөх, архины хор нөлөө" сэдвээр сургалт хийсэн.	
2.14.	Оюутны дотуур байр, хүүхдийн зуслан, амралтын газруудад сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах ажлыг тогтмол хийх (буруу зан үйлд нөлөөлөх байдлыг тандах)	Оюутны дотуур байранд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйл явагдах боломжтой эсэхийг тандах, судална.	-	-	- Зуны амралтаар хүүхдийн 2 зуслан ажилласан ба "Янзага" хүүхдийн зусланд 6 ээлжийн 1200 хүүхэд, "Найрамдлын эрдэнэс" хүүхдийн зусланд 3 ээлжийн 1500 хүүхэд амарсан. Зуслангийн үйл ажиллагаанд хяналт хийж ба амрагч хүүхдүүд авч эхлэхээс өмнө Орхон, Булган аймгийн Цагдаагийн газраас мансууруулах ургамлын устгал хийх зорилгоор хор цацах ажлыг 1 удаа зохион байгуулсан. - Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2 сэтгэл зүйчтэй хамтран 4 өдрийн хугацаанд "Найрамдлын эрдэнэс" зусланд ажиллаж, амарч байсан хүүхдүүд, эцэг эхчүүд нийт 222 хүнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнд: Хоолны хордлогын шинжтэй хэвтэн эмчлүүлж байгаа 198 хүн (89.1%) буюу 11 том хүн (5.5%), 187 хүүхэдтэй (94.5%) уулзаж ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Гадуур, гэртээ байгаа хүүхдүүдийн 24 эцэг эхчүүдэд цахимаар зөвлөгөө өгч ажилласан. - Орхон аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүн, Эрүүл мэндийн газрын Сэтгэцийн эрүүл мэнд, Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Эрүүл ахуй, халдвар хамгааллын	100

					хяналтын улсын байцаагч хамтран Политехникийн коллежийн дотуур байранд хяналт хийж ажилласан. Хяналтын явцад ноцтой зөрчил гараагүй бөгөөд зөвлөн туслаж ажиллалаа.	
Зорилт 3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, өргөжүүлэх						
3.1	Сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, гэр бүл, амьдрах ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.	-	-	-Эрдэнэт клиникийн сэтгэл заслын өрөөнд Сэтгэл засалч эмч ажиллаж 7 хоногт 2 удаа хэвтэн эмчлүүлэгчдэд сэтгэл заслын эмчилгээ хийж тогтмол ажилладаг. - БОЭТ-сэтгэцийн кабинет нь сэтгэц-нийгмийн сэргээн засах хөдөлмөр засал, ном, хөгжим, арт терапи зэрэг заслын эмчилгээ хийж ажиллаж байна. -Сэтгэц наркологийн “Оюу” эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдаж байна. - Эрүүл мэндийн газрын Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв, Эрдэнэт сувилал сэтгэл заслын кабинетаар давхардсан тоогоор 449 иргэн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсанаас 315 иргэн нь танхимаар, 134 иргэн буюу цахимаар үйлчлүүлсэн. Үүнээс гэр бүлийн асуудлаар 169 буюу 37.6%, сэтгэл зүйн хөнгөн тулгамдсан асуудлаар буюу 280 хүн буюу 62.3%, нь үйлчлүүлсэн байна. -Донтолтыг бууруулах чиглэлээр Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн хөгжлийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/12 дугаартай албан бичиг, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/292 дугаар захирамж, удирдамжийн дагуу архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв”, “Аддиктологийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, улмаар орон нутагт бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх төв байгуулах, донтох эмгэгийн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудын 10 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судалсан. Мөн орон нутагт нутагшуулах зорилгоор санал оруулан ажилласан.	90
3.2	Мансуурах болон сэтгэц нөлөөт эмийн жорын бичилт, олголт,	Мансуурах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор	-	-	- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилдэг 12 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эмийн сангуудаар 1	70

	хадгалалтын хяналтыг сайжруулах, жор бичилтийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	бичилтийг цахимжуулж, хяналт тавих, цахим жорын систем ашиглах талаарх сургалт зохион байгуулсан байна.			удаагийн хяналт хийж, хяналтаар хэрэгжилт дунджаар 95,5%-тай гарсан бөгөөд өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 1,0%-аар хэрэгжилт сайжирсан байна. Мөн жилийн эцсийн байдлаар мансууруулах эмийн жорыг 3 байгууллагад 657ш, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 12 байгууллагуудад 4,085 ширхэг тус тус шифрлэж олгосон. - Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, энгийн эмийн жор бичилт хэрэглээний талаар болон шинэ эмийн танилцуулга сургалтыг зохион байгуулсан. 70 эмч, мэргэжилтэн хамрагдсан. - Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар Архи, тамхи, мансууруулах бодис, сэтгэц нөлөөт эмийн талаар мэдээллийг тогтмол оруулж иргэдэд хүргэж байна. - "Эмийн зохистой хэрэглээ" сэдвээр богино хэмжээний бичлэгийн уралдаан зохион байгуулж 15 бичлэгээс 3-ийг шалгаруулж шагнасан.	
3.3	Ахмад настны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах	Тэтгэвэрт гарахын өмнө болон гарсны дараах сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх сургалтын төв, дамжаа, ангийг үүсгэн байгуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг тогтмол зохион байгуулдаг болсон байна.	-	-	- Аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас Ахмадын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон аймгийн хэмжээнд 4 дүгээр сарын 01-с 1 сарын хугацаанд 5 соёлын төвүүдэд ахмадуудад зориулсан “Шугаман бүжиг” заах, чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөл бүрдүүлсэн ба 7 хоногт 3 удаа буюу тус үйл ажиллагаанд нийт 3600 ахмад настан, иргэд хамрагдсан байна. - Залуучуудын ордон болон “Эрдэнэс” бүжгийн клуб, “Солонго” бүжгийн клубуудад бүжиг болон шугаман бүжгийн сургалт 7 хоногт 4 удаа 20 гаруй ахмад тогтмол хичээллэж байна. - Орхон аймгийн БТСГ-аас Ахмадын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоногт 1 удаа спорт зааланд үнэ төлбөргүй тоглох цаг гаргасан, тус хугацаанд доод тал нь 20 ахмад тогтмол хамрагддаг. - Эрүүл мэндийн сайдын А/517 дугаар тушаалын дагуу иргэдэд гэрийн эргэлт хийж 45 иргэнд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлж, 10 ахмад настанд гарын бэлэг гардуулсан. - Эрүүл мэндийн сайдын А/517 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, ICOPE сорилоор настны сэтгэл	100

					гутрал, сэтгэцийн эмгэгийг 412 ахмадыг үнэлж асран хамгаалагчдад зөвлөгөө өгч ажилласан. - Архины хамаарлаас шалтгаалж амиа хорлох оролдлого хийсэн ахмад настанг Сэтгэц, наркологийн эмнэлэгт холбон зуучилж хэвтүүлэн тусламж үйлчилгээнд хамруулсан. - “Ахмадаа хайрлая” уриан дор ахмадын эрүүл мэндийг дэмжих сар болгон ажиллаж “Эрүүл настан-2025” 5 хоногийн аяныг өрнүүлж 197 ахмад буюу эрэгтэй 59, эмэгтэй 138 ахмад хамрагдсанаас 25 хүнийг лавлагаа шатлалд онош тодруулахаар илгээсэн. Диспансерийн хяналтанд 9 хүн хянагдаж эмчлэн эрүүлжүүлж байна. Аяны хүрээнд “Ахмад настанд илрэх физиологийн өөрчлөлт”, “Амны хөндийн арчилгаа” сургалт зохион байгуулагдаж, ахмадуудыг хүчилтөрөгчийн коктейлээр амин дэмжүүлсэн. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд 386 ахмад настнаас 100-е үнэлгээ хийж сэтгэл зүйн байдлыг үнэлсэн. Үүнээс сэтгэл гутралын хөнгөн зэрэгтэй 3 ахмад илэрсэнийг сэтгэл зүйчид холбон зуучилж ажилласан.	
	Хэрэгжилтийн дундаж хувь-93.6%					

ТАЙЛАН НЭГТГЭСЭН : СЗТҮХА

Б.БАТЦЭЦЭГ

ХЯНАСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Орхон аймаг

2025 оны 12 дугаар сарын 16

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Хүрсэн түвшин	Тайлбар	Хэрэгжилтийн хувь
1.	Үйл ажиллагаа 7: Амиа хорлолтын түвшин	Промиль	100,000 хүн амд 16	2	2025 оны 10 дугаар сарын байдлаар амиа хорлолт 2 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 40%-аар буурсан.	100
2.	Үйл ажиллагаа 9: Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг дэмжиж ажилласан байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага	Тоо	50	55	55 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж өмнөх оноос 10%-иар өссөн.	80
3.	Үйл ажиллагаа 13: Хүүхэд, өсвөр үеийн сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн талаар зөв дадал эзэмшсэн эцэг, эх асран хамгаалагчид	Тоо	50-аар нэмэгдэнэ	102	Сэтгэцийн өвчлөл 1371 бүртгэгдэж, 102 асран хамгаалагч буюу 7.4% хамрагдсан.	75
4.	Үйл ажиллагаа 19: Архи, согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи, дам тамхидалтын хор нөлөөг таниулах сурталчлах, соён Гэгээрүүлэх арга хэмжээнд хамрагдсан байгууллагын хорт зуршлаас татгалзсан хүн	Тоо	40	51	174 хүн хөтөлбөрт хамрагдаж 51 хүн буюу 29.3% татгалзсан.	85
5.	Үйл ажиллагаа 19: Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ	Тоо	30	6	Аймгийн хэмжээнд 2025 онд Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв 2-оор нэмэгдэж өмнөх үеэс 50%-аар нэмэгдсэн.	100
6.	Үйл ажиллагаа 22: Амьдрах ур чадварт сургасан сэтгэцийн эмгэгтэй хүн	Тоо	50	11	Сэтгэцийн эмгэгтэй, хөнгөвчлөх эмчилгээтэй 11 хүнийг амьдрах ур чадварт сургаж, өмнөх оны мөн үеэс 27,2%-иар өссөн.	85
7.	Үйл ажиллагаа 23: Сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадамж эзэмшсэн хүүхэд, өсвөр үеийн эмч	Тоо	16	4751	Эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх сургагч багш бэлтгэж, өмнөх оноос 90%-иар нэмэгдсэн.	100
8.	Үйл ажиллагаа 27: Архинаас гарах	Тоо	90 хүн	73	73 хүн хамрагдаж дадал хэвшлээ	85

	төсөлд хамрагдан дадал хэвшлээ өөрчилсөн хүн				өөрчилсөн.	
9.	Үйл ажиллагаа 33: Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх арга зүй эзэмшсэн эмч, мэргэжилтэн	Тоо	3 дүүрэг, 15 аймаг	28	Анхан шатны эрүүл мэндийн төвийн 53 эмч нараас 28 эмч хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 28.8%-иар өссөн.	80
10.	Үйл ажиллагаа 5: Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй сэтгэл зүйч	Тоо	30	5	Аймгийн хэмжээнд 2025 онд шинээр 2 сэтгэл зүйч ажиллаж эхэлсэн нь өмнөх оноос 33.3% өссөн.	100
11.	Үйл ажиллагаа 5: Аймаг, дүүргийн түвшинд ажилладаг сэтгэцийн эмч	Тоо	58	6	2025 онд Сэтгэцийн эмч 1-ээр хасагдаж өмнөх оноос 14.2% буурсан.	90
12.	Үйл ажиллагаа 6: Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тусламж, үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх ор	Тоо	281	38	Хэвтүүлэн эмчлэх ор нэмэгдээгүй.	80
13.	Үйл ажиллагаа 13: Эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэгдсэн багш, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан	Тоо	20	28	Сумын анхан шатны 28 эмч хамрагдсан.	95
14.	Үйл ажиллагаа 13: Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрагдсан эцэг, эх асран хамгаалагчид	Тоо	1000	2272	Боловсрол олгох сургалтанд 2272 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан байна.	95
15.	Үйл ажиллагаа 13: Сургуулийн орчинд ажиллах сэтгэл зүйч	Хувь	10%	91,6%	Аймгийн хэмжээнд 24 сургуульд 22 сэтгэл зүйч ажиллаж байна.	91
16.	Үйл ажиллагаа 14: Хүүхдийн байгууллагын орчин дахь сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээний тоо	Тоо	2 дүүрэг, баруун бүсийн 4 аймаг	4	4 цогц арга хэмжээ зохион байгуулж өмнөх үеэс 33.3% өссөн.	90
17.	Үйл ажиллагаа 25: Аймаг дүүргийн хэмжээнд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх төв, тасаг, нэгж	Тоо	10	5	2025 онд шинээр нэмэгдээгүй.	90
18.	Үйл ажиллагаа 27: Архинд донтох эмгэгийн эмчилгээнд хамрагдалт	Хувь	30%	29.4%	Архинд донтох эмчилгээнд 434 хүн хамрагдсан ба өмнөх оны мөн үеэс 29.4%-иар буурсан байна.	90
19.	Үйл ажиллагаа 28: Анхан шатлалд СЭМ-ийн чиглэлээр тусламж, үйлчилгээ	Тоо	5%	10.4%	Орхон аймгийн нийт хүн амын 10.4% тусламж үйлчилгээ авсан.	80

	авсан хүн					
20.	Үйл ажиллагаа 28: Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмийн тоо/төрөл	Хувь	25	29	2025 онд өөрчлөлт ороогүй.	90
21.	Үйл ажиллагаа 28: Хөнгөлөлтэй эмийн жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмийн тоо, төрөл	Тоо	11	14	Хөнгөлөлтэй эмийн жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмийн тоо өөрчлөгдөөгүй.	90
22.	Үйл ажиллагаа 30: Мансууруулах бодист донтох эмгэгийн эмчилгээний хамрагдалт	Тоо	45%	0.16%	Тамхи татдаг 284 хүнээс 174 хүн хамрагдаж 61.2%-ийн хамрагдалттай. Нийт хүн амын 0.16% хамрагдсан.	80
23.	Үйл ажиллагаа 31: Коломбо хөтөлбөрийн ахисан түвшний сургалтад хамрагдсан сургагч багш	Тоо	38	2	CARS хөтөлбөрт Сэтгэцийн 2 эмч хамрагдаж бэлтгэгдсэн.	100
24.	Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхад суралцсан сэтгэл засалч	Тоо	68	2	Сэтгэцийн 2 эмч хамрагдсан.	90
25.	Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн олон улсын сургалтын хөтөлбөрт хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	Тоо	-	1	Олон Улсын Эерэг сэтгэл заслын сургалтад сэтгэцийн 1 эмч хамрагдсан.	100
26.	Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхжуулах сургалтад хамрагдсан шүүх шинжилгээний эмч	Тоо	16	0	Сургалтад хамрагдсан шүүх шинжилгээний эмч байхгүй.	0
27.	Үйл ажиллагаа 32: Донтох эмгэг судлалаар мэргэшсэн эмч	Тоо	43	6	Сэтгэцийн 6 эмч Донтох эмгэг судлалаар мэргэшсэн.	100
28.	Үйл ажиллагаа 34: Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан	Тоо	100	0	Мэргэшсэн нийгмийн ажилтан байхгүй.	0
	Хэрэгжилтийн дундаж хувь					83.6

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Б.БАТЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ЧАНАР ЭРСДЭЛ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ